ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.04.18 № 341.

танай ____________ -ны № ____________ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ
ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Аймгийн 2024 оны төсвийн нийт орлого 79,682.3 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 76,355.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпорац ААТҮГ-т олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс нийт 5,608.5 сая төгрөгийн, Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т олгосон нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс нийт 799.2 сая төгрөгийн, Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлээс нийт 472.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, харьяа байгууллагуудад 7,564.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос нийт 2,452.4 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан, харьяа байгууллагуудын аудитаар 167.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,354.3 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд 153.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 16.9 сая төгрөгийн 3 заалт зөвлөмж хүргүүлсэн зэрэг үндэслэлээр "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн болно.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, хангалтгүй хэрэгжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хариуцлага тооцох, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулан, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тусгай сангуудын зээлийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах, батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг тухай бүр олгож, хяналтыг сайжруулах, орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, тооцоо судалгаатай боловсруулж батлуулах, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг тусган батлуулах талаар 7 зөвлөмж бүхий аудитын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 1. Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан 26 хуудастай.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан 29 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

8225020424

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЙМГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАА-2025/001-НА-СТА-ТЕЗ

2025 он

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.04.18 № 138

танай ____________ -ны № ______________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Г.ЧИНБАТ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.10, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5, 15.2.6 дугаар заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1. Харьяа байгууллагуудад 7,564.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос нийт 2,452.4 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;
2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпораци ААТҮГ-т олгосон урт хугацаат зээлээс нийт 5,608.5 сая төгрөгийн, дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т олгосон нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс 799.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн үлдэгдэлтэй;
3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн 687.2 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүү, алдангийн авлагын үлдэгдэлтэй;

4. Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 472.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
5. Харьяа байгууллагуудын аудитаар 167.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,354.3 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд 153.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 16.9 сая төгрөгийн 3 заалт зөвлөмж хүргүүлсэн;
6. Орон нутгийн өмчит 4 хуулийн этгээд нийт дүнгээр 1,120.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант оны санхүүгийн үр дүн, өмч хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах асуудлыг онцолж байна. Тухайлбал:

- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,236.5 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар нэмэгдсэн;
- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,392.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 13,473.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 1,257.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 161.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулсан;
- Орон нутгийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс орлого тасарч, харьяа байгууллагуудад олгох санхүүжилтийг 7,564.8 сая төгрөгөөр дутуу олгон, тайлант онд шинээр 2,452.4 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;
- Сумдын ой тэмдэглэхэд 1,400.0 сая төгрөгийн дэмжлэгийг 14 сумд олгосноос 693.0 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн хууль зөрчин хоол хүнс, шагналд зарцуулсан.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

- Төсөвт тодотгол хийхдээ хууль тогтоомжид заасан шалгуурыг харгалзахгүйгээр төсвийн нийт орлого, зардлыг 8,447.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж батлан, Засаг дарга ерөнхий дансаар 80.0 хувийг зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан;
- Засаг дарга ерөнхий данснаас 3,438.4 сая төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд шагнал, урамшуулалд, 1,400.0 сая төгрөгийг сумдын ой тэмдэглэхэд, 1,942.6 сая төгрөгийг бусад хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсэн;
- Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 2,100.0 сая төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг хэлбэрээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар анхан шатны нотлох баримтгүйгээр бусдад олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Ерөнхий Сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламжид тусгасан 7 арга хэмжээг 95.7 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан бөгөөд дүгнээгүй байна.

Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнээгүй, Засаг даргын Тамгын газруудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 92.2 хувьтай, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 90.4 хувьтай, албан бичгийн шийдвэрлэлт 65.5 хувьтай, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг дүгнээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГҮНЖИДМАА

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:

Дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа

Аудитын менежер:

Д.Эрдэнэчимэг

Ахлах аудитор:

Д.Цэрэнханд
М.Атарцэцэг

Аудитор:

Н.Гэрэлмаа
Э.Сүнжидмаа

2025 оны 04 дүгээр сар

Уг тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70483413 дугаар утсаар харилцана уу.

ХАЯГ:
Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402

**Хүснэгтийн тайлбар** ... 2
**1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** ... 3
**2. АУДИТ ХИЙСЭН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН** ... 3
**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН** ... 3
**2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН** ... 3
**3. АУДИТЫН ТАЙЛАН** ... 6
**3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ** ... 6
**3.1.1 Аудит хийсэн үндэслэл** ... 6
**3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ** ... 6
**3.1.3 Аудитын арга зүй** ... 6
**3.1.4 Материаллаг байдлын түвшин** ... 7
**3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ** ... 7
**3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж** ... 7
**3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн** ... 7
**3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР** ... 8
**3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан** ... 8
**3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан** ... 8
**3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** ... 8
**3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан** ... 8
**4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ... 8
**4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** ... 8
**4.2 АВЛАГА** ... 9
**Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага** ... 10
**Төрийн сангийн авлага** ... 10
**Төсвийн байгууллагын авлага** ... 11
**Төсөл, сангийн авлага** ... 11
**4.3 УРЬДЧИЛГАА** ... 11
**4.4 БАРАА МАТЕРИАЛ** ... 11
**4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** ... 13
**4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ** ... 13
**4.7 ӨР ТӨЛБӨР** ... 14
**4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО** ... 15
**4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ... 15
**Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит** ... 16
**Түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит** ... 16
Түүвэрт 60 тусгай сан, 25 төсвийн байгууллага, 2 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, нийт 87 байгууллага, тусгай сан хамрагдсан байна. ... 16
**4.10 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА** ... 16
**4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ** ... 17
**4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА** ... 17
**5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ** ... 18
**5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ** ... 18
**5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ** ... 18

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| ААТҮГ | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БОАЖГ | Байгаль, орчин аялал жуулчлалын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЖДҮДС | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МХС | Мал хамгаалах сан |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| НДШ | Нийгмийн даатгалын шийтгэл |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит Төсвийн үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТЭДС | Тариалан эрхлэлтийг дэмжих сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн
Хүснэгт 2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч
Хүснэгт 3.Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 4.Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 5. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 6.Бараа материал данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 7.Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 8.Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр
Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 10. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр
Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо
Хүснэгт 12 Өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# 1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## 2. АУДИТ ХИЙСЭН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,658.3** | **42,662.6** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 8,954.4 | 13,051.1 |
| 33 | АВЛАГА | 14,171.2 | 12,967.2 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 165.4 | 168.8 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 5,168.6 | 5,904.4 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 383.7 | 558.5 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 11,815.1 | 10,012.5 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **97,992.8** | **105,225.0** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 97,992.8 | 105,225.0 |
| 39100 | Газар | - | - |
| 39200 | Биет хөрөнгө | 75,796.9 | 82,840.7 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 22,195.9 | 22,384.4 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **138,651.1** | **147,887.6** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 13,563.3 | 15,461.2 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,445.6 | 6,056.7 |
| 41300 | Өглөг | 2,605.8 | 4,705.0 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 839.8 | 1,351.8 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10,117.7 | 9,404.4 |
| 42200 | Урт хугацаат зээл | 10,117.7 | 9,404.4 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **125,087.7** | **132,426.5** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 125,087.7 | 132,426.5 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 17,819.2 | 17,738.8 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 14,915.8 | 14,915.8 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 85,214.1 | 92,870.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,138.6 | 6,901.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **138,651.1** | **147,887.6** |

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **175,560,022.5** | **94,582,436.9** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 16,661,981.0 | 32,928,667.1 |
| 110 | Орлогын албан татвар | 12,114,969.0 | 26,784,801.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 12,438,105.8 | 22,467,541.3 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (629,962.2) | (959,323.0) |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | - | - |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 306,825.4 | 5,276,583.4 |
| 1104 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | - | - |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | - | - |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,521,084.1 | 3,493,646.6 |
| 114 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | - | - |
| 115 | Онцгой албан татвар | - | - |
| 116 | Тусгай зориулалтын орлого | - | - |
| 117 | Гадаад үйл ажиллагааны орлого | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 2,025,927.8 | 2,650,218.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 80,251,673.7 | 59,389,064.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 45,228,823.6 | 16,433,773.6 |
| 121 | Хөрөнгийн орлого | 1,673,280.0 | 294,140.5 |
| 122 | Тусламжийн орлого | - | - |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 33,349,570.1 | 42,661,150.9 |
| 124 | Зээлийн орлого | - | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 78,646,367.7 | 2,264,704.9 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **121,129,790.7** | **68,792,546.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 120,956,282.0 | 68,792,546.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 51,032,095.9 | 66,640,666.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 13,293,939.2 | 21,000,405.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,737,188.0 | 2,772,703.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,437,875.8 | 17,217,331.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,277,424.9 | 4,085,867.0 |
| 2105 | Нормативт зардал | 362,993.9 | 287,232.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,658,503.6 | 2,348,855.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 376,875.3 | 437,533.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,085,269.0 | 8,547,676.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,802,026.4 | 9,943,060.9 |
| 211 | ХҮҮ | - | - |
| 212 | ТАТААС | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 69,924,186.1 | 2,151,879.6 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 173,508.7 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 54,430,231.8 | 25,789,890.6 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 2,500.0 | - |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 15,702,465.0 | 18,976,349.0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **38,730,266.8** | **6,813,541.6** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 89,909,297.0 | 89,909,297.0 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (1,276,009.2) | (1,276,009.2) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 88,633,287.8 | 88,633,287.8 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (259,192.6) | (259,192.6) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (2,065,619.0) | (2,065,619.0) |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 49,006.2 | 49,006.2 |
| 8 | Зарласан ногдол ашиг | - | - |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 38,730,266.8 | 38,730,266.8 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **125,087,749.1** | **125,087,749.1** |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 125,087,749.1 | 125,087,749.1 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 728,186.3 | 728,186.3 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **125,815,935.4** | **125,815,935.4** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (236,723.6) | (236,723.6) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (68,180.0) | (68,180.0) |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 87,721.4 | 87,721.4 |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 6,827,706.4 | 6,827,706.4 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **132,426,459.7** | **132,426,459.7** |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөг)*

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2023 оны 12-р сарын 31** | **2024 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **147,929,875.8** | **89,006,515.7** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 16,661,981.0 | 32,928,667.1 |
| 110 | Орлогын албан татвар | 12,115,264.8 | 26,784,801.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 12,440,221.1 | 22,467,541.3 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (631,781.7) | (959,323.0) |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | - | - |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 306,825.4 | 5,276,583.4 |
| 1104 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | - | - |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | - | - |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,520,785.3 | 3,493,646.6 |
| 114 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | - | - |
| 115 | Онцгой албан татвар | - | - |
| 116 | Тусгай зориулалтын орлого | - | - |
| 117 | Гадаад үйл ажиллагааны орлого | - | - |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 2,025,930.8 | 2,650,218.7 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 518,409.8 | 536,538.8 |
| 1181 | Газрын төлбөр | 765,285.3 | 1,498,352.6 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 737,703.4 | 615,166.3 |
| 1183 | Бусад татвар | 4,532.3 | 161.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 45,438,269.9 | 53,852,136.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,415,419.8 | 10,896,845.0 |
| 121 | Хөрөнгийн орлого | 1,673,280.0 | 294,140.5 |
| 122 | Тусламжийн орлого | - | - |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 33,349,570.1 | 42,661,150.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 85,829,624.9 | 2,225,712.3 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **124,161,494.9** | **61,734,987.2** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 124,161,494.9 | 61,734,987.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 47,343,103.7 | 59,620,362.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 14,458,659.1 | 22,213,509.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,227,699.7 | 3,139,970.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,028,599.8 | 16,196,523.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,577,432.8 | 3,139,487.2 |
| 2105 | Нормативт зардал | 16,607.3 | 13,331.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 410,764.4 | 2,293,107.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 367,771.3 | 425,989.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,342,188.2 | 5,959,079.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,913,381.1 | 6,239,364.6 |
| 211 | ХҮҮ | - | - |
| 212 | ТАТААС | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,818,391.2 | 2,114,624.4 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 23,768,380.9 | 27,271,528.5 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 154,352.0 | 46,514.4 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 23,968,545.3 | 22,859,990.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 23,968,545.3 | 22,859,990.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,968,545.3 | 22,859,990.8 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | - | - |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (23,814,193.3) | (22,813,476.4) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (1,194,998.9) | (354,106.3) |
| 14 | Бусад эх үүсвэр | - | - |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 1,194,998.9 | 354,106.3 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | - | - |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | - | - |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(1,240,811.3)** | **4,103,945.9** |
| **101** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **10,195,170.1** | **8,954,358.8** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **8,954,358.8** | **13,051,104.7** |

# 3. АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### 3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

### 3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорих аудитын горимыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### 3.1.3 Аудитын арга зүй

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүвэрээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### 3.1.4 Материаллаг байдлын түвшин

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны батлагдсан төсвийн 95,867.2 сая төгрөгийн 2.0 хувь буюу 1,917.3 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 445.6 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 109,613.6 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 109,840.2 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 45 төсвийн байгууллага, гүйцэтгэлээр санхүүждэг 99 байгууллагын тогтмол зардлын данс, орон нутгийн өмчит 13 хуулийн этгээд, 21 төрийн сан, 58 төсөл сан, хяналтад байгаа 15, нийт 251 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

### 3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

### 3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны "Э-тайлан" программаар нэгтгэн гаргасан ба дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:++

*Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн*

| А. Үндсэн тайлан | Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан | В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга |
|---|---|---|
| Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | НББ-ийн бодлого, зарчим<br>3-21 дүгээр тодруулгууд |
| Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 1а, 1б, 2а, 2б тодруулга |
| Санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | |
|---|---|---|
| Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

### 3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 147,887.6 сая төгрөг болж, өмнөх оноос 6.7 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч* *(сая төгрөг)*

| Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 40,658.3 | 42,662.6 | 2,004.3 | 28.8 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 97,992.8 | 105,225.0 | 7,232.2 | 71.2 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **138,651.1** | **147,887.6** | **9,236.5** | **100.0** |
| Нийт өр төлбөр | 13,563.3 | 15,461.2 | 1,897.8 | 10.5 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 125,087.7 | 132,426.5 | 7,338.7 | 89.5 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **138,651.1** | **147,887.6** | **9,236.5** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт хөрөнгө өмнөх оноос 9,236.5 сая төгрөгөөр өссөн нь төрийн байгууллагууд 8,399.7 сая төгрөгийн биет бус хөрөнгийг улс орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар бүртгэж, ОНӨААТҮГ-ууд 1,166.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь голлон нөлөөлжээ.

### 3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 6,813.5 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн 7,548.4 сая төгрөг, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 4.8 сая төгрөгийн тус тус эерэг (*орлого нь зардлаасаа их*) үзүүлэлттэй, орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 605.4 сая төгрөгийн төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 134.2 сая төгрөгийн сөрөг (*зардал нь орлогоосоо их*) үзүүлэлттэй гарсан байна.

### 3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 80.4 сая төгрөгөөр, дахин үнэлгээний нөөц 237.1 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 7,656.2 сая төгрөгөөр, нийт 7,338.7 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар үйл ажиллагааны мөнгөн орлого 89,006.5 төгрөг, зарлага 61,734.9 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 4,103.9 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлэгдсэн байна.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,954.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,051.1 сая төгрөг болж, 4,096.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3.Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр* *(сая төгрөг)*

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0.9 | 8.5 | 7.6 | 0.0 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 8,953.4 | 13,051.1 | 4,097.7 | 100.0 |
| 1.Төрийн сангийн харилцах | 8,475.7 | 12,377.2 | 3,901.5 | 94.8 |
| 2. Арилжааны банкны харилцах | 477.7 | 673.9 | 196.2 | 5.2 |
| **Дүн** | **8,954.4** | **13,051.1** | **4,096.7** | **100.0** |
| Үүнээс, байгууллагын төрлөөр | | | | |
| ОНӨҮГ | 461.9 | 650.3 | 188.4 | 5.0 |
| Төрийн сан | 3,559.5 | 3,356.4 | (203.1) | 25.7 |
| Төсвийн байгууллага | 4,072.7 | 7,327.4 | 3,254.7 | 56.1 |
| Төсөл/сан | 860.2 | 1,717.0 | 856.8 | 13.2 |
| **Дүн** | **8,954.4** | **13,051.1** | **4,096.7** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,096.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө 188.4 сая төгрөг, төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгө 3,254.7 сая төгрөг, төсөл сангийн мөнгөн хөрөнгө 856.8 сая төгрөгөөр тус тус өсөж, төрийн сангийн мөнгөн хөрөнгө 203.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,254.7 сая төгрөгөөр өссөн нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлууд он дамжин хийгдэж, хөрөнгө оруулалт барьцаа дансанд 620.2 сая төгрөгийг нэмж байршуулан, сумдын ХХС-гаас зээл олгоогүйтэй холбоотой байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдлийн 94.8 хувь буюу 12,377.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 5.2 хувь буюу 673.9 сая төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 650.3 сая төгрөгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3,356.4 сая төгрөгийг төрийн сан, 1,717.0 сая төгрөгийг төсөл сан, 7,327.4 сая төгрөгийг төсвийн байгууллага тус тус эзэлж байна.

Арилжааны банкин дахь нийт 650.3 сая төгрөг нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

**Төсөл, сангийн мөнгөн хөрөнгө**

- Сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа дансны эхний үлдэгдэл 221.6 сая төгрөг, тайлант онд 169.3 сая төгрөгийн барьцааг нэмж төвлөрүүлэн, 29.4 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд хандиваар шилжүүлэн авч, 24.4 сая төгрөгийн барьцааг урсгал зардалд зарцуулан, 5.0 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 362.1 сая төгрөг байна.
- Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 475.3 сая төгрөг, тайлант онд 842.0 сая төгрөгийн барьцааг байршуулан, 221.6 сая төгрөгийг /чанарын баталгаа, техник хяналтын зардал, зураг төсөв/ зарцуулан, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,095.8 сая төгрөг байна.
- Техникийн хяналтын дансны эхний үлдэгдэл 76.5 сая төгрөг бөгөөд тайлант онд орлого зарлагын гүйлгээ гараагүй.

*Аудитын илрүүлэлт:*

- *Анхан шатны баримтгүй гүйлгээ хийж, зарцуулсан 413.1 сая төгрөг (Солонго дулааны станц ОНӨААТҮГ-337.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ-47.2 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-17.9 сая төгрөг, Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-8.7 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-2.1 сая төгрөг)*
- *БХНСС-аас урсгал зардлыг санхүүжүүлсэн. (Эрдэнэ сумын БХНСС-18.0 сая төгрөг, Есөнбулаг сумын БХНСС-6.0 сая төгрөг)*

## 4.2 АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 14,171.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,967.1 сая төгрөг болж, 1,204.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4.Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр* *(сая төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 34.1 | 47.4 | 13.3 | 0.4 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.0 | | 0.0 | - |
| Татаас, санхүүжилтийн авлага | 185.5 | 104.4 | (81.1) | 0.8 |
| Зээлийн хүүгийн авлага | 94.6 | 79.9 | (14.7) | 0.6 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 4,842.2 | 3,844.9 | (997.3) | 29.7 |
| Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/ | 28.7 | 26.3 | (2.4) | 0.2 |
| Бусад авлага | 5,133.5 | 5,737.8 | 604.3 | 42.5 |
| Зээлийн авлага | 3,852.6 | 3,126.4 | (726.2) | 24.1 |
| Хувь хүмүүст олгосон зээлийн авлага | 3,499.4 | 2,979.2 | (520.2) | 95.3 |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 353.2 | 147.2 | (206.0) | 4.7 |
| **Дүн** | **14,171.2** | **12,967.1** | **(1,204.1)** | **100.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 7,333.6 | 6,931.5 | (402.1) | 53.4 |
| Төрийн сан | 503.2 | 457.8 | (45.4) | 3.5 |
| Төсвийн байгууллага | 5,599.8 | 4,946.4 | (653.4) | 38.1 |
| Төсөл/Сан | 734.5 | 631.4 | **(103.1)** | 4.8 |
| **Дүн** | **14,171.2** | **12,967.1** | **(1,204.1)** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансны үлдэгдлийн 29.9 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 42.5 хувийг бусад, 24.1 хувийг зээлийн, 0.8 хувийг татаас санхүүжилтийн, 0.6 зээлийн хүүгийн авлага, 0.4 хувийг ажиллагсадтай холбоотой авлага эзэлж байна.

Авлагын бууралтад ОНӨААТҮГ-ын авлага 997.3 сая төгрөг, зээлийн авлага 726.2 сая төгрөгөөр тус тус барагдсан нь голлон нөлөөлжээ.

Бусад авлага 604.3 сая төгрөгөөр өссөн нь Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын авлага 522.9 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын авлага 260.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 472.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. (*дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу*)

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн авлага дансны 2,708.0 сая төгрөгийн үлдэгдлийн 25.3 хувь буюу 687.2 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага бөгөөд 21.0 хувь буюу 141.9 сая төгрөгийн зээлийг Шүүхэд хандаагүй, арга хэмжээ аваагүй байна.

**Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага**

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын эхний үлдэгдэл 7,333.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,931.5 сая төгрөг болж, 402.1 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдлийн 80.3 хувийг Алтай орон сууцны корпораци ААТҮГ, 13.4 хувийг Ундарга-Алтай ААТҮГ, 3.5 хувийг Солонго дулааны станц ААТҮГ, 2.1 хувийг Жаргалан сумын Суурин дулаан ААТҮГ, 0.3 хувийг Нийтлэг үйлчилгээний газар ААТҮГ, 0.3 хувийг Гэгээн нуур-Цэвэр ус ОНӨҮГ, 1.0 хувийг Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ болон Инновац судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-ын авлага тус тус эзэлж байна.

**Төрийн сангийн авлага**

Төрийн сангийн авлагын дансны эхний үлдэгдэл 503.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 457.8 сая төгрөг болж, 45.4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь урьд оны өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Төсвийн байгууллагын авлага**

Төсвийн байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 5,599.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,946.4 сая төгрөг болж, 653.3 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх онд үүссэн 627.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

**Төсөл, сангийн авлага**

Төсөл, сангийн авлага дансны эхний үлдэгдэл 734.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 631.4 сая төгрөг болж, 103.1 сая төгрөгөөр буурсан байна. Авлага буурсан нь зээлийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

*Илрүүлэлт:*
- *Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй 219.4 сая төгрөг байна. (Шарга сумын ЗДТГ-151.7 сая төгрөг, Солонго дулааны станц ААТҮГ-67.7 сая төгрөг );*
- *Он дамжсан авлага 40.0 сая төгрөгийг барагдуулаагүй. (Алтай сумын ЗДТГ-40.0 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ, Ундарга-Алтай ААТҮГ, Орон нутгийн өмчийн газар);*
- *Тусгай сангийн зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги 472.7 сая төгрөгийг гэрээт хугацаанд төлөөгүй (ЖДҮДС-415.0 сая төгрөг, мал хамгаалах сан-40.2 сая төгрөг, ТЭДС-17.5 сая төгрөг);*
- *Санхүүгийн тайланд тусгасан өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулсан бараа материалыг бөөн дүнгээр эд хариуцагч шаардахаар гаргасан, хөрөнгийн тооллогыг хуурамчаар үйлдсэн, бараа материалын төлбөр, ажиллагсдын нэр дээр авсан урьдчилгааг хамаарал бүхий этгээдийн дансаар шилжүүлэн авсан зэрэг санхүүгийн сахилга бат сул байна. (Эрдэнэ сумын ЗДТГ);*
-

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон Хоршоо хөгжүүлэх сангийн төлбөрийн актын үлдэгдэл хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 687.2 сая төгрөгийг төлүүлээгүй байна. Энэ нь эх үүсвэр дутагдах, зээлийн эргэлтийг удаашруулах эрсдэлийг үүсгэж байна.

## 4.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 165.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 168.7 сая төгрөг болж, 3.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 5. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Солонго дулааны станц ААТҮГ | 149.0 | 149.0 | 0 | 88.3 |
| Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ | 16.4 | 16.4 | 0 | 9.7 |
| Марал-Алтай ӨЭМТ | | 1.8 | 1.8 | 1.1 |
| Эрдэнэ сумын ЗДТГ | | 1.5 | 1.5 | 0.9 |
| **Дүн** | **165.4** | **168.7** | **3.2** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Солонго дулааны станц ААТҮГ-ын хүлээж аваагүй дулааны шугамын ажлын 149.0 сая төгрөг, Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ-ын дуусаагүй шугамын ажлын 16.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд Марал-Алтай ӨЭМТ-1.8 сая, Эрдэнэ сумын ЗДТГ-1.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлага нэмж үүссэн байна.

## 4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 5,168.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,904.4 сая төгрөг болж, 736.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6.Бараа материал данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Түүхий эд материал | 239.1 | 362.5 | 123.4 | 6.1 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 182.6 | 319.7 | 137.1 | 88.2 |
| Эм боох материал | 56.5 | 42.9 | (13.7) | 11.8 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 147.3 | 144.0 | (3.3) | 2.4 |
| Хангамжийн материал | 2,550.7 | 3,136.9 | 586.2 | 53.1 |
| Бичиг хэргийн материал | 36.0 | 43.4 | 7.4 | 1.4 |
| Аж ахуйн материал | 1,939.6 | 2,421.7 | 482.1 | 77.2 |
| Сэлбэг хэрэгсэл | 62.9 | 64.5 | 1.6 | 2.1 |
| Түлш, шатах тослох материал | 43.7 | 50.6 | 6.9 | 1.6 |
| Барилгын засварын материал | 31.5 | 41.6 | 10.1 | 1.3 |
| Хүнсний материал | | 1.3 | | |
| Бусад хангамжийн материал | 437.1 | 513.9 | 76.8 | 16.4 |
| Биологийн хөрөнгө | 27.5 | 0.0 | (27.5) | 0.0 |
| Мал амьтад | 2,204.0 | 2,261.0 | 57.0 | 38.3 |
| **Дүн** | **5,168.6** | **5,904.4** | **735.8** | **100.0** |
| **Үүнээс, байгууллагын төрлөөр** | | | 0.0 | |
| ОНӨҮГ | 344.8 | 399.2 | 54.4 | 6.8 |
| Төсвийн байгууллага | 4,816.7 | 5,491.0 | 674.3 | 0.9 |
| Төсөл/сан | 6.9 | 14.3 | 7.4 | 0.2 |
| **Дүн** | **5,168.4** | **5,904.4** | **736.0** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн байгууллагын бараа материал 674.3 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал 54.4 сая төгрөгөөр, төсөл сангийн бараа материал 7.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Сумдын 100 жилийн ойтой холбоотой Есөнбулаг сумын ЗДТГ-100.0 сая төгрөгөөр, Цогт сумын ЗДТГ-93.7 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа материал 65.6 сая төгрөгөөр, Алтай сумын ЗДТГ 55.4 сая төгрөгөөр, Баян-Уул сумын ЗДТГ-63.7 сая төгрөгөөр тус тус өссөн нь төсвийн байгууллагын бараа материалын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Сумдын ХХС-гийн бараа материал дансанд 145.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй /Халиун сум-36.3 сая төгрөг, Баян-Уул сум-34.6 сая төгрөг, Бигэр сум-19.2 сая төгрөг, Жаргалан сум-15.2 сая төгрөг, Бугат сум-11.7 сая төгрөг, Цээл сум-9.4 сая төгрөг, Алтай сум-5.3 сая төгрөг, Төгрөг сум-4.0 сая төгрөг, Дарив сум-2.1 сая төгрөг/ оёдлын тоног төхөөрөмжүүд байгаа бөгөөд 6-7 жил ашиглалтгүй хадгалагдаж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй 615.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Дарив сумын ЗДТГ-144.4 сая төгрөг, Цээл сумын ОНХС-127.7 сая төгрөг, Жаргалан сумын ЗДТГ-119.1 сая төгрөг, Дэлгэр сумын ОНХС-37.5 сая төгрөг, Халиун сумын ХХС-36.3 сая төгрөг, Бугат сумын ОНХС-38.6 сая төгрөг, Дарив сумын ОНХС 34.5 сая төгрөг, Есөнбулаг сумын ОНХС-24.7 сая төгрөг, Бигэр сумын ЗДТГ-22.0 сая төгрөг, Алтай сумын ОНХС-17.5 сая төгрөг, Эрдэнэ сумын ОНХС-8.4 сая төгрөг, Жаргалан сумын ОНХС-4.2 сая төгрөг, Цогт сумын ОНХС-0.7 сая төгрөг);*
- *Шатахууны зарцуулалт тодорхой бус, тооцоо бодоогүй, 153.9 сая төгрөгийг эд хариуцагч шатахууны зарцуулалтыг хөтлөөгүй.(Аймгийн ЗДТГ)*
- *Халиун сумын ОНХС 36.0 сая төгрөгийн өвс тэжээлийг олгосон бараа материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан.*
- *Бараа материалыг акталж устгаагүй, шаардах хуудсаар зарлагадсан 27.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Баян-Уул сумын ЗДТГ-24.7 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-2.4 сая төгрөг)*
- *Бараа материалын биет тооллогоор 10.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. (Дарив сумын ОНХС-5.0 сая төгрөг, Есөнбулаг сумын ИТХ-4.3 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-0.7 сая төгрөг)*
- *Бараа материал 4.9 сая төгрөгийг орлого аваагүй, шууд зарлагадсан. (Тайшир сумын ЗДТГ, Тонхил сумын ОНХС-4.9 сая төгрөг)*
- *Данс бүртгэлд тусгасан 4.7 сая төгрөгийн мал бодитоор оршин байхгүй.(Есөнбулаг сумын ЗДТГ)*

**Нөөцийн бараа**

Нөөцийн бараа дансны эхний үлдэгдэл 383.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 558.5 сая төгрөг болж, 174.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7.Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Барааны нөөц | 60.7 | 55.9 | (4.8) | 10.0 |
| Үрийн нөөц | 109.7 | 109.7 | 0.0 | 19.6 |
| Тэжээлийн нөөц | 106.5 | 243.6 | 137.1 | 43.6 |
| Бусад нөөц | 106.8 | 149.3 | 42.5 | 26.7 |
| Дүн | 383.7 | 558.5 | 174.8 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нөөцийн барааны үлдэгдэл дансны 106.0 сая төгрөг буюу 47.7 хувийг Цээл сум, 23.9 сая төгрөг буюу 13.6 хувийг Дэлгэр, 22.4 сая төгрөг буюу 13.0 хувийг Есөнбулаг сум, 22.5 сая төгрөг буюу 12.7 хувийг бусад сумд эзэлж байна.

## 4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,815.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10,012.5 сая төгрөг болж, 1,802.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 8.Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт(+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 32.0 | 9,128.2 | 9,096.2 | 91.2 |
| БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 11,783.0 | 884.3 | (10,898.7) | 8.8 |
| Дүн | 11,815.1 | 10,012.5 | (1,802.6) | 100.0 |
| Үүнээс, байгууллагын төрлөөр | | | 0 | |
| ОНӨҮГ | 180.0 | 180.0 | 0.0 | 1.8 |
| Төсөл, сан | 11,635.0 | 9,832.5 | (1,802.5) | 98.2 |
| Дүн | 11,815.0 | 10,012.5 | (1,802.5) | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй харин төсөл, сангуудын бусад эргэлтийн хөрөнгө 1,802.5 сая төгрөгөөр буурсан нь сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээнүүдийг бараа материалын данснаас хасаж, үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ОНХС-д олон жил хүлээж аваагүй төсөл арга хэмжээ 329.9 сая төгрөгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд бүртгэсэн байна. (Тонхил сумын ОНХС-233.0 сая төгрөг, Эрдэнэ сумын ОНХС-96.9 сая төгрөг)*

Илрүүлэлт:

## 4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 97,992.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 105,225.0 сая төгрөг болж, 7,232.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр* *(сая төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Биет хөрөнгө | 75,796.9 | 82,840.7 | 7,043.8 | 78.7 |
| Биет бус хөрөнгө | 22,195.9 | 22,384.4 | 188.5 | 21.3 |
| **Дүн** | **97,992.8** | **105,225.0** | **7,232.2** | **100.0** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 38,894.5 | 37,728.3 | (1,166.2) | 35.9 |
| Төсвийн байгууллага | 59,093.1 | 67,492.7 | 8,399.6 | 64.1 |
| Төсөл/сан | 5.2 | 4.08 | (1.1) | 0.0 |
| **Дүн** | **97,992.8** | **105,225.0** | **7,232.2** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 7,232.2 сая төгрөгөөр өссөн нь сумдын 100 жилийн ойтой холбоотой хандив тусламжаар болон төсвийн хөрөнгөөр хөрөнгө нэмж бүртгэсэнтэй

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

холбоотой байна. Тухайлбал: Бугат, Хөхморьт, Эрдэнэ сумдын ариун цэврийн цэвэрлэх байгууламж 1,745.9 сая төгрөгөөр, сумдын ойтой холбоотой 3,725.0 сая төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар тус тус нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Үндсэн хөрөнгийг орлого авч, данс бүртгэлд тусгаагүй 1,161.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Есөнбулаг сумын ОНХС-678.4 сая төгрөг, Цогт сумын ОНХС-258.8 сая төгрөг, Халиун сумын ОНХС-79.1 сая төгрөг, Жаргалан сумын ОНХС-57.4 сая төгрөг, Тайшир сумын ОНХС-41.9 сая төгрөг, аймгийн ИТХ-21.0 сая төгрөг, Шарга сумын ОНХС-16.7 сая төгрөг, Баян-Уул сумын ОНХС-8.0 сая төгрөг)*
- *Есөнбулаг сумын ЗДТГ нь 477.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагад ашиглуулсан.*
- *Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй 56.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Дарив сумын ЗДТГ-56.0 сая төгрөг, АХТҮГ, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ)*
- *Үндсэн хөрөнгө биетээр оршин байхгүй 27.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. (Шарга сумын ЗДТГ-24.9 сая төгрөг, Марал-Алтай ӨЭМТ-2.9 сая төгрөг)*
- *Есөнбулаг сумын ИТХ нь 8.7 сая үндсэн хөрөнгийг тогтоол, шийдвэргүйгээр шилжүүлсэн байна.*

## 4.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12,774.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 15,461.2 сая төгрөг болж, 2,686.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр* *(сая төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн (+), Буурсан (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Богино хугацаат өр төлбөр дүн | 2,656.7 | 6,056.7 | 3,400.0 | 39.2 |
| Ажиллагсадтай холбоотой өглөг | 11.3 | 294.5 | 283.2 | 4.9 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 121.2 | 1,131.1 | 1,009.9 | 18.7 |
| Бусад өглөг | 1,684.5 | 3,279.4 | 1,594.9 | 54.1 |
| Урьдчилж орсон орлого | 839.7 | 1,351.8 | 512.1 | 22.3 |
| Урт хугацаат өр төлбөр дүн | 10,117.7 | 9,404.4 | (713.3) | 60.8 |
| Урт хугацаат зээл | 10,117.7 | 9,404.4 | (713.3) | 60.8 |
| **Дүн** | **12,774.4** | **15,461.2** | **2,686.8** | **100.0** |
| *Үнэлэс, байгууллагын төрлөөр* | | | | |
| ОНӨҮГ | 11,211.5 | 10,403.6 | (807.9) | 67.3 |
| Төрийн сан | 0.0 | 110.3 | 110.3 | 0.7 |
| Төсвийн байгууллага | 934.9 | 3,442.9 | 2,508.0 | 22.3 |
| Төсөл/сан | 628.0 | 1,504.3 | 876.3 | 9.7 |
| **Дүн** | **12,774.4** | **15,461.2** | **2,686.8** | **100.0** |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр 807.9 сая төгрөгөөр буурч, төсвийн байгууллагын өр төлбөр 2,508.0 сая төгрөг, төсөл сангийн өр төлбөр 876.3 сая төгрөгөөр, төрийн сангийн өр төлбөр 110.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр 3,400.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагуудын өр төлбөр нь тайлант онд сум болон байгууллагуудад санхүүжилт дутуу олгосонтой холбоотойгоор тогтмол зардлын 1,700.8 сая төгрөгийн, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, татварт 478.4 сая төгрөгийн, бусад бараа үйлчилгээний зардалд 273.2 сая төгрөгийн, нийт 2,452.4 сая төгрөгийн өр төлбөр тайлант онд шинээр үүссэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр 713.3 сая төгрөгөөр буурсан нь Алтай орон сууцны корпораци ААТҮГ -ийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 60.8 хувь буюу 9,404.4 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр, 39.2 хувь буюу 6,056.7 сая төгрөг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпораци ААТҮГ-т 2019 онд олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс өмнөх онуудын 4,399.4 сая төгрөг, 2024 оны 1,209.1 сая төгрөг, нийт 5,608.5 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Хөгжлийн банкнаас Алтай орон сууцны корпораци ААТҮГ-т 2019 онд олгосон урт хугацаат 7,830.5 сая төгрөгийн зээлээс 2021 онд 2,118.3 сая төгрөг, 2022 онд 1,267.2 сая төгрөг, 2023 онд 1,013.8 сая төгрөг, нийт 4,399.4 сая төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Сангийн яам, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Ундарга-Алтай ААТҮГ-т нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг сайжруулах төслийн зээлээс хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 799.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Богино хугацаат өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 88.5 сая төгрөг (Солонго дулааны станц ААТҮГ-79.0 сая төгрөг, Дэлгэр сумын ИТХ-9.5 сая төгрөг)*
- *Тайлант онд 2,687.4 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй. (ТЕЗ-2,452.4 сая төгрөг, аймгийн ЗДТГ-134.3 сая төгрөг, Марал-алтай ӨЭМТ-32.9 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-27.7 сая төгрөг, Цогт сумын ЗДТГ-24.1 сая төгрөг, Шарга сумын ИТХ-10.3 сая төгрөг, Ойн анги-5.5 сая төгрөг)*

## 4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 125,087.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 132,426.5сая төгрөг болж, 7,338.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо* *(сая төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 32,735.0 | 32,654.6 | (80.4) | 24.7 |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 17,819.2 | 17,738.8 | (80.4) | 13.4 |
| Өмч /төрийн/ ТӨҮГ | 14,915.8 | 14,915.8 | 0.0 | |
| Хуримтлагдсан үр дүн | 85,214.1 | 92,870.3 | 7,656.2 | 70.1 |
| Өмнөх үеийн үр дүн | 46,483.8 | 38,730.3 | (7,753.5) | 29.2 |
| Тайлант үеийн үр дүн | 38,730.3 | 54,140.0 | 15,409.7 | 40.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,138.6 | 6,901.5 | (237.1) | 52.1 |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 125,087.7 | 132,426.5 | 7,338.8 | 100.0 |

*Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал данс 80.4 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 237.1 сая төгрөгөөр тус тус буурсан. Хуримтлагдсан үр дүн 7,656.2 сая төгрөгөөр өссөн нь шинээр хэрэгжсэн төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын нэмэлт санхүүжилт өмнөх оноос 17.0 хувиар буюу 582.0 сая төгрөгөөр өссөн байна.

## 4.9 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад 20 төсвийн төвлөрүүлэн захирагч, 125 төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлангийн аудитад хамрагдахаас 56 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 87 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй татан буугдсан 2 ААТҮГ-ын санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 47,798.3 сая төгрөгийн 261 алдаа илэрснийг аудитын явцад удирдлага, нягтлан бодогчийн зөвшөөрснөөр залруулга хийсэн.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 6,388.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 43.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3,703.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,641.7

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, зөрчил гаргасан 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

**Дүгнэлт гаргасан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын дүгнэлт гаргасан 56 байгууллагаас өөрчлөлтгүй 6, хязгаарлалттай 49, сөрөг 1 (Бигэр сумын ЗДТГ) байгууллага байна.

Төсвийн 20 төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, өөрчлөлтгүй 1, хязгаарлалттай 19 /Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан,Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд, Гуулин тосгон/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 27,619.0 сая төгрөгийн 112 алдаа илэрснээс бүрэн залруулсан.

Аудитаар нийт 27,619.0 сая төгрөгийн 112 зөрчил илэрснээс 203.8 сая төгрөгийн зөрчилд 48 төлбөрийн акт, 7,881.3 сая төгрөгийн зөрчилд 170 албан шаардлага, 153.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 23,080.2 сая төгрөгийн 48 зөвлөмж, 2,100.0 сая төгрөгийн 2 асуудлыг шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторт, Засгийн газрын нэгтгэсэн тайланд тусгуулах 3 саналыг Үндэсний аудитын газарт уламжилсан. *Iдэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/*

**Түүвэрт хамруулсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит**

Түүвэрт 60 тусгай сан, 25 төсвийн байгууллага, 2 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, нийт 87 байгууллага, тусгай сан хамрагдсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 13,512.3 сая төгрөгийн 142 алдаа илэрснийг залруулсан байна.

Аудитаар нийт 5,150.9 сая төгрөгийн 140 зөрчил илэрснээс 318.4 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт, 4,810.5 сая төгрөгийн зөрчилд 105 албан шаардлага, 22.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлжээ. */дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/*

**Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайлангийн аудит**

Орон нутгийн өмчийн 12 хуулийн этгээдээс 8 байгууллагад дүгнэлт гарган, 2 байгууллагыг түүвэрт хамруулан, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитын дүгнэлт гаргасан 8 байгууллагаас өөрчлөлтгүй 2, хязгаарлалттай 6 (Алтайн тохижилт үйлчилгээний газар ААТҮГ, Алтай орон сууцны корпораци ААТҮГ, Солонго дулааны станц ААТҮГ, аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ, Нийтлэг үйлчилгээ УТҮГ, Суурин дулаан ААТҮГ) дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 6,666.9 сая төгрөгийн 7 алдаа илэрснийг залруулсан байна.

Аудитаар нийт 1,207.0 сая төгрөгийн 28 зөрчил илэрснээс 231.2 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 975.8 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 1 санал хүргүүлжээ. */дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/*

## 4.10 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ.Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт 9,865.5 сая төгрөгийг үнэ төлбөргүй гарсан зардлаар тайлагнасан.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

- Тонхил сумын ИТХ, Жаргалан сумын ЗДТГ, Баянтоорой тосгоны захирагчийн албаны байгууллагаас авах авлага 33.4 сая төгрөгийг ТӨҮГ-ын авлагаар тайлагнасан.
- Дарив сумын ЗДТГ нь 28.6 сая төгрөгийн мал амьтдыг биологийн хөрөнгө ангилалд бүртгэсэн.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 3,572.8 сая төгрөгийн 4 зөрчил[1] илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 3,572.8 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

## 4.11 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,521.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 35.0 хувьтай хангалтгүй байна.

Х*үснэгт 12. Өмнөх санхүүгийн тайлангаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт* *(сая төгрөг)*

| Үзүүлэлт | Өмнөх оны шийдвэр | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | | | |
| Албан шаардлага | 2.0 | 167.8 | 1.0 | 58.7 | 1.0 | 109.1 | 35.0 |
| Зөвлөмж | **3.0** | 2,353.9 | | 0.0 | 3.0 | 2,353.9 | 0.0 |
| **Дүн** | **5.0** | **2,521.7** | **1.0** | **58.7** | **4.0** | **2,463.0** | **35.0** |

- Аймгийн ИТХ-д өгсөн 1 зөвлөмж хэрэгжилтийг ирүүлсэн боловч зөрчил давтан гарсан тул биелэлтээр тайлагнаагүй.
- Аймгийн Засаг даргад өгсөн 1 зөвлөмж, 3 албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлсэн боловч зөрчил давтан гарсан тул биелэлтээр тайлагнаагүй.

## 4.12 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2024 онд 6 орон тоотой ажиллахаас 4 орон тоотой ажилласан.

Тус газар нь Засаг даргын баталсан "Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д тусгасны дагуу тухайн жилд аймгийн төвийн болон сумдын нийт 40 байгууллага, тусгай зориулалтын сангийн 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийхээр төлөвлөснөөс 36 байгууллагад хяналт, шалгалт хийсэн.

Мөн тусгай захиалгат буюу Сангийн яамны нэгдсэн удирдамжаар 2 байгууллагад, иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу 3 байгууллагад төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийсэн байна. Дотоод аудит хийгээгүй. Хяналт шалгалтаар нийт 883,116.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 15,377.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 843,114.6 мянган төгрөгийн зөрчилд 56 заалт бүхий 16 албан шаардлага, 24,613.7 мянган төгрөгийн 35 заалт бүхий 10 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна

Сангийн яамны Төрийн сангийн газраас 2023-2024 оны Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд хяналт шалгалтаар 21 зөвлөмжүүдийг хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2024 оны 11 сард гаргаж хүргүүлсэн байна.

*Тухайлбал: Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг баримтлан ажиллах, баталсан хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгох, нэмэлт төсвийн дансаар Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д зааснаас бусад санхүүжилтийн эрхийг нээхгүй байх, цахим архивын нэгж бүрдүүлэх, хэлтсийн мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, орлон ажиллах албан тушаалтныг тодорхой болгох, зарим зөвшөөрөөгүй бүртгэлийн дансыг хаалгах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.*

## 4.13 Нягтлан бодох бүртгэлийн стандарт, тайлагналтай холбоотой

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны аудитаар дараах 4 байгуулагатай холбоотой нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн 6 албан тушаалтнуудад хуулийн дагуу сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

## 5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн 6.6 хувиар өссөн үзүүлэлттэй;
2. Орон нутгийн өмчит 3 хуулийн этгээд нийт дүнгээр 1,120.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
3. Харьяа байгууллагуудад санхүүжилтийг дутуу олгосноос тайлант онд 2,452.4 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;
4. Алтай орон сууц корпораци ААТҮГ нь 5,608.5 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй;
5. Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 472.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
6. Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн авлага дансны 2,708.0 сая төгрөгийн үлдэгдлийн 25.3 хувь буюу 687.2 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн зээлийн авлага бөгөөд 21.0 хувь буюу 141.9 сая төгрөгийн зээлийг Шүүхэд хандаагүй, арга хэмжээ аваагүй;
7. Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шийдвэрийн хэрэгжилт 35.0 хувьтай байна.

### 5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

1. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эдийн засгийн зорилтот түвшний биелэлт, санхүүгийн болон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
2. Төрийн аудитын байгууллагаас аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Харьяа байгууллагуудын санхүүжилтийг баталсан төсвийн хуваарийн дагуу бүрэн олгож, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.
2. Тусгай сангуудын хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулан, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тусгай сангуудын зээлийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг авч ажиллах.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ХАВСРАЛТ.

### Хавсралт 1. Тусгай сангуудаас олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл

/сая төгрөг/

| Төрөл | Өмнөх онуудад олгосон зээл | Олгосон зээл 2024 онд | Хугацаа хэтэрсэн зээл | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндсэн зээл | Хүү | Алданги | дүн |
| ТЭДС | 90.7 | - | 15.8 | 0.5 | 1.2 | 17.5 |
| МХС | 318.0 | - | 40.2 | - | - | 40.2 |
| ЖДҮДС | 1,160.0 | 115.0 | 353.5 | 7.7 | 53.8 | 415.0 |
| **Дүн** | **1,568.7** | **115.0** | **409.5** | **8.2** | **55.0** | **472.7** |

## Хавсралт 2. Дүгнэлт гаргасан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| ДД | Байгууллагын нэр | Дүгнэлт | | | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Сахилгын шийтгэл оногдуулах | | Зөвлөмж | | Монгол Улсын Ерөнхий аудиторт санал | | УАГ-т санал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өөрчлөлт | Хязгаарлалттай | сөрөг | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн |
| 1 | Алтай сум | - | 2 | - | 11 | 191.1 | 2 | 8.1 | 2 | 2.1 | 5 | 156.2 | - | - | 2 | 24.6 | - | - | - | - |
| 2 | Баян-Уул сум | - | 2 | - | 15 | 455.7 | 6 | 202.0 | 1 | 3.5 | 5 | 77.8 | - | - | 3 | 172.4 | - | - | - | - |
| 3 | Бигэр сум | - | 1 | 1 | 10 | 77.4 | - | - | - | - | 8 | 77.4 | 2 | - | 0 | - | - | - | - | - |
| 4 | Бугат сум | - | 2 | - | 10 | 867.0 | 2 | 650.7 | - | - | 6 | 51.3 | - | - | 2 | 165.0 | - | - | - | - |
| 5 | Дарив сум | - | 2 | - | 12 | 452.3 | 2 | 45.0 | 1 | 1.0 | 8 | 328.6 | - | - | 1 | 77.8 | - | - | - | - |
| 6 | Дэлгэр сум | - | 2 | - | 16 | 342.0 | 4 | 117.2 | 4 | 4.8 | 4 | 130.6 | - | - | 4 | 89.4 | - | - | - | - |
| 7 | Жаргалан сум | - | 2 | - | 11 | 442.3 | 4 | 166.9 | 1 | 0.4 | 4 | 127.1 | - | - | 2 | 147.9 | - | - | - | - |
| 8 | Тайшир сум | - | 2 | - | 25 | 277.7 | 9 | 135.6 | 5 | 12.9 | 8 | 73.1 | - | - | 3 | 56.2 | - | - | - | - |
| 9 | Тонхил сум | - | 2 | - | 28 | 2,609.7 | 11 | 2,279.2 | 3 | 4.4 | 9 | 197.3 | 1 | - | 4 | 128.7 | - | - | - | - |
| 10 | Төгрөг сум | - | 2 | - | 17 | 504.0 | 6 | 318.2 | 1 | 0.7 | 10 | 185.1 | - | - | 0 | - | - | - | - | - |
| 11 | Халиун сум | - | 2 | - | 8 | 298.4 | 1 | 64.0 | - | - | 6 | 65.7 | - | - | 1 | 168.7 | - | - | - | - |
| 12 | Хөхморьт сум | - | 2 | - | 11 | 225.9 | 5 | 120.5 | - | - | 5 | 35.7 | - | - | 1 | 69.6 | - | - | - | - |
| 13 | Цогт сум | - | 2 | - | 15 | 610.5 | 3 | 93.9 | 1 | 24.8 | 9 | 300.3 | - | - | 2 | 191.5 | - | - | - | - |
| 14 | Цээл сум | - | 2 | - | 8 | 122.0 | 2 | 24.2 | 1 | 3.9 | 4 | 92.2 | - | - | 1 | 1.8 | - | - | - | - |
| 15 | Чандмань сум | - | 2 | - | 11 | 433.3 | 3 | 30.6 | 2 | 3.3 | 5 | 317.1 | - | - | 1 | 82.3 | - | - | - | - |
| 16 | Шарга сум | - | 2 | - | 20 | 557.6 | 5 | 73.5 | 3 | 4.7 | 8 | 112.1 | - | - | 4 | 367.3 | - | - | - | - |
| 17 | Эрдэнэ сум | - | 2 | - | 33 | 1,487.6 | 18 | 1,185.7 | 4 | 9.3 | 8 | 270.6 | - | - | 3 | 22.0 | - | - | - | - |
| 18 | Гуулин тосгон | | 2 | - | 12 | 436.3 | 6 | 424.3 | 2 | 2.6 | 3 | 7.1 | - | - | 1 | 2.4 | - | - | - | - |
| 19 | Баянтоорой тосгон | 1 | 1 | - | 8 | 748.1 | 4 | 721.2 | 1 | 1.0 | 3 | 26.0 | - | - | - | - | - | - | - | - |
| 20 | Есөнбулаг сум | - | 4 | - | 44 | 12,017.9 | 11 | 10,906.6 | 9 | 45.5 | 22 | 1,053.2 | - | - | 2 | 12.6 | - | - | - | - |
| 21 | Аймаг дүн | 2 | 3 | - | 42 | 1,132.7 | 5 | 124.3 | 7 | 79.0 | 25 | 758.6 | 2 | 153.9 | 3 | 16.9 | - | - | - | - |
| 22 | Төсвийн ерөнхийлөн захирагч | - | 1 | - | 16 | 36,748.9 | 3 | 9,927.5 | - | - | 5 | 3,438.4 | - | - | 8 | 21,283.0 | - | - | - | - |
| | **НИЙТ ДҮН** | **3.00** | **44** | **1** | **383** | **61,038.3** | **112** | **27,619.0** | **48** | **203.8** | **170** | **7,881.3** | **5** | **153.9** | **48** | **23,080.2** | - | - | - | - |

## Хавсралт 3. Түүвэрт хамрагдсан байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| ДД | Байгууллагын нэр | түүвэрт хамрагдсан | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн |
| 1 | Алтай сум | 4 | 10 | 296.3 | 6 | 271.6 | 1 | 5.8 | 3 | 18.9 | - | - |
| 2 | Баян-Уул сум | 4 | 16 | 703.4 | 8 | 639.4 | 2 | 28.5 | 6 | 35.5 | - | - |
| 3 | Бигэр сум | 4 | 13 | 651.9 | 8 | 179.6 | 1 | 3.3 | 4 | 469.1 | - | - |
| 4 | Бугат сум | 4 | 11 | 563.1 | 6 | 465.6 | 1 | 0.9 | 4 | 96.6 | - | - |
| 5 | Дарив сум | 4 | 16 | 504.7 | 8 | 203.5 | 1 | 1.4 | 7 | 299.8 | - | - |
| 6 | Дэлгэр сум | 4 | 23 | 1,195.9 | 8 | 200.1 | 5 | 24.1 | 9 | 961.8 | 1 | 9.9 |
| 7 | Жаргалан сум | 4 | 13 | 505.3 | 8 | 422.9 | - | - | 5 | 82.4 | - | - |
| 8 | Тайшир сум | 4 | 5 | 63.5 | 2 | 18.2 | - | - | 3 | 45.3 | - | - |
| 9 | Тонхил сум | 4 | 17 | 1,091.6 | 9 | 835.0 | 2 | 11.5 | 6 | 245.1 | - | - |
| 10 | Төгрөг сум | 4 | 5 | 40.3 | 3 | 33.0 | 1 | 6.8 | 1 | 0.5 | - | - |
| 11 | Халиун сум | 4 | 20 | 554.0 | 10 | 282.3 | 1 | 16.4 | 9 | 255.2 | - | - |
| 12 | Хөхморьт сум | 4 | 7 | 27.5 | 3 | 3.0 | 1 | 19.0 | 3 | 5.6 | - | - |
| 13 | Цогт сум | 4 | 16 | 993.2 | 9 | 270.5 | 1 | 56.3 | 6 | 666.4 | - | - |
| 14 | Цээл сум | 4 | 14 | 1,050.1 | 9 | 812.3 | 1 | 10.4 | 4 | 227.5 | - | - |
| 15 | Чандмань сум | 4 | 10 | 382.3 | 5 | 353.9 | 1 | 6.2 | 4 | 22.3 | - | - |
| 16 | Шарга сум | 4 | 20 | 355.0 | 12 | 278.5 | 1 | 11.8 | 6 | 54.4 | 1 | 10.3 |
| 17 | Эрдэнэ сум | 4 | 11 | 1,117.0 | 7 | 1,078.3 | 1 | 18.0 | 3 | 20.8 | - | - |
| 18 | Есөнбулаг сум | 5 | 22 | 6,981.8 | 13 | 6,262.7 | 2 | 9.6 | 5 | 707.8 | 2 | 1.8 |
| 19 | Аймгийн төвийн байгууллагууд | 12 | 33 | 1,586.2 | 8 | 901.9 | 8 | 88.6 | 17 | 595.7 | - | - |
| | **НИЙТ ДҮН** | **85** | **282** | **18,663.3** | **142** | **13,512.3** | **31** | **318.4** | **105** | **4,810.6** | **4** | **22.0** |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Хавсралт 4. Орон нутгийн өмчит байгууллагуудын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| ДД | Байгууллагын нэр | Дүгнэлт | | | | | | Илрүүлсэн зөрчил | | Аудитаар залруулсан | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | сөрөг | Аудитад хамрагдаагүй | татгалзсан | түүвэрт хамрагдсан | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн |
| 1 | Дарив дулаан ОНӨААТҮГ | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | Суурин дулаан ОНӨААТҮГ | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Эрдэнэ эрчим хүч ААТҮГ | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Алтайн тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ | - | 1 | - | - | - | - | 7 | 240.1 | 1 | 52.4 | 1 | 0.3 | 5 | 187.4 | - | - | - | - |
| 5 | Алтай орон сууцны корпораци ААТҮГ | - | 1 | - | - | - | - | 3 | 234.8 | 1 | 4.6 | 1 | 230.1 | 1 | - | - | - | - | - |
| 6 | Солонго дулааны станц ААТҮГ | - | 1 | - | - | - | - | 11 | 7,163.9 | 2 | 6,574.8 | - | - | 8 | 589.2 | 1 | - | - | - |
| 7 | Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ | 1 | - | - | - | - | - | 6 | 9.1 | 1 | 8.3 | 2 | 0.8 | 1 | - | - | - | 2 | - |
| 8 | Ундарга-Алтай ААТҮГ | 1 | - | - | - | - | - | 3 | 11.3 | - | - | - | - | 3 | 11.3 | - | - | - | - |
| 9 | Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ | - | 1 | - | - | - | - | 6 | 96.3 | 2 | 26.9 | - | - | 4 | 69.4 | - | - | - | - |
| 11 | Нийтлэг үйлчилгээ УТҮГ | - | 1 | - | - | - | - | 2 | 118.6 | - | - | - | - | 2 | 118.6 | - | - | - | - |
| 12 | Орон сууцны алба ОНӨААТҮГ | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | **НИЙТ ДҮН** | **2** | **6** | **-** | **2** | **-** | **2** | **38** | **7,874.0** | **7** | **6,667.0** | **4** | **231.2** | **24** | **975.8** | **1** | **0** | **2** | **-** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ААБ 5.5 : АСУУДЛЫН БҮРТГЭЛ

**Аудитын нэр:Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**
Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Засаг дарга

**Аудитын код: ГАА-2025/001/СТА-ТЕЗ**
Тайлангийн хугацаа: 2024.01.01-2024.12.31

| № | АГАДУТ | АГАДУТ-ын дэд анги | Алдаа зөрчлийн товч утга | Асуудлын ангилал | Мөнгөн дүн (сая.төг) | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гарсан шийдвэр | Байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гарсан шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| | | | ТЕЗ-ийн зөрчлийн дүн | | 2,452.4 | 0.00 | 2,452.40 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 1 | Ажил гүйлгээний анги | Богино хугацаат өглөг | Харьяа байгууллагуудад санхүүжилтийг дутуу олгосноос тогтмол зардлын 1,700,823.3 мянган төгрөгийн, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, татварт 478,380.2 мянган төгрөгийн, бусад бараа үйлчилгээний зардалд 273,211.6 мянган төгрөгийн, нийт 2,452,415.1 мянган төгрөгийн өр төлбөр тайлант онд шинээр үүссэн байна. | Санхүүгийн аудитын асуудал | 2,452.4 | Материаллаг | 2,452.4 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь батлаж хэрэгжүүлэх" | Хуулийн хэрэгжилт | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| 2 | Ажил гүйлгээний анги | Нийт зардал | Харьяа байгууллагуудын аудитаар 167,579.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,354,315.7 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд 153,931.4 мянган төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 16,911.6 мянган төгрөгийн 3 заалт зөвлөмж, 2,100,000.0 мянган төгрөгийн 1 асуудлыг хуулийн байгууллагад хүргүүлсэн. | Санхүүгийн аудитын асуудал | 0.0 | Материаллаг | 0.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх". | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Албан шаардлага | Тайлбаргүй | Тайлбаргүй | Албан шаардлага |
| 3 | Дансны үлдэгдэл | Авлага | Мал хамгаалах сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 472,700.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна | Санхүүгийн аудитын асуудал | 0.0 | Материаллаг | 0.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь батлаж хэрэгжүүлэх" | Хуулийн хэрэгжилт | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| | | | Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар | | 23,248.6 | 0.0 | 23,248.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | | | |
| 1 | Ажил гүйлгээний анги | Тусламж, дэмжлэг | Орон нутгийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс сумдад 2,620,790.8 мянган төгрөг, аймгийн төсвийн байгууллагуудад 4,944,035.5 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос, тайлант онд шинээр өр төлбөр үүсэж, төсвийг зохистой удирдан зохион байгуулаагүй байна. | Санхүүгийн аудитын асуудал | 7,564.8 | Материаллаг бус | 7,564.8 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 13 дугаар тогтоол | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| 2 | Ажил гүйлгээний анги | Татварын болон татварын бус орлого | Төлөвлөлтийг бодитой тооцоогүйгээс аймгийн орон нутгийн 4 нэр төрлийн орлого 9,565,267.4 мянган төгрөгөөр, түрээсийн орлогыг 18,079.6 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлээгүйгээс нийт 9,583,347.1 мянган төгрөгөөр тасарсан. | Санхүүгийн аудитын асуудал | 9,583.3 | Материаллаг бус | 9,583.3 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 13 дугаар тогтоол | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |

| № | АГАДҮТ | АГАДҮТ-ын дэд анги | Алдаа зөрчлийн товч утга | Асуудлын ангилал | Мөнгөн дүн (сая.төг) | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гарсан шийдэл | Байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гарсан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 3 | Ажил гүйлгээний анги | Өөрийн орлого | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ЗДТГ болон бусад төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар 2022 онд 342,162.8 мянган төгрөгийн, 2023 онд 445,655.3 мянган төгрөгийн, 2024 онд 86,947.8 мянган төгрөгийн өөрийн орлого орж зарцуулсан боловч төсвийн төлөвлөгөөнд өөрийн орлогыг төлөвлөж өгөөгүй байна. | Санхүүгийн аудитын асуудал | 87.0 | Материаллаг | 87.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн тодруулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" 33 дугаар зүйлийн 33.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого" | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| 4 | Ажил гүйлгээний анги | Өөрийн орлого | Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг Тонхил, Халиун сумууд огт төлөвлөөгүй, Дарив, Эрдэнэ, Есөнбулаг сумууд 800.0-1,700.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19-282 хувиар давж биелэн нийт 469,100.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн боловч, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна. | Санхүүгийн аудитын асуудал | 469.1 | Материаллаг | 469.1 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн тодруулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" 33 дугаар зүйлийн 33.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого" | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| 5 | Ажил гүйлгээний анги | Хоолны зардал | Төсвийн зардлын ангилал зөрчин Дэлгэр сумын ИТХ-д 1,000.0 мянган төгрөг, Алтай сумын ЗДТГ-т 510.0 мянган төгрөг, Цээл сумын ЗДТГ-т 945.0 мянган төгрөг, Баян-Уул сумын ИТХ-д 800.0 мянган төгрөг, Гуулин тосгоны Захирагчийн албанд 2,400.0 мянган төгрөг, Баянтоорой тосгоны Захирагчийн албанд 360.0 мянган төгрөг, нийт 6,015.0 мянган төгрөгийн хоолны зардлыг төлөвлөж, батлуулсан байна. | Санхүүгийн аудитын асуудал | 6.0 | Материаллаг | 6.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн тодруулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал "Ангилал шинэчлэн батлах тухай" | байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журам баримтлаагүй | Зөвлөмж | Тайлбаргүй | Тайлбаргүй | Зөвлөмж |
| 6 | Ажил гүйлгээний анги | Зардал | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 31,901.7 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон. | Нийцлийн аудитын асуудал | 0.0 | Материаллаг | 0.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн тодруулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ". | Хуулийн хэрэгжилт | Албан шаардлага | Тайлбаргүй | Тайлбаргүй | Албан шаардлага |
| 7 | Ажил гүйлгээний анги | Зардал | Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 2,100,000.0 мянган төгрөгийг буцалтгүй тусламж дэмжлэг хэлбэрээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бусаар анхан шатны нотлох баримтгүйгээр олгосон. | Санхүүгийн аудитын асуудал | 2,100.0 | Материаллаг | 2,100.0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн тодруулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.6-т "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" | Хуулийн хэрэгжилт | Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, уг асуудлыг МУ-ын Ерөнхий аудиторт шалгуулахаар санал уламжлав. | Аймгийн Засаг даргын 2025 оны 04.21-н өдрийн 1/535 дугаар албан бичгээр ирүүлсэн | ОНХС-гаас зориулалт бусаар зарцуулсан тул шийдвэрийг хэвээр үлдээв. | Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, уг асуудлыг МУ-ын Ерөнхий аудиторт шалгуулахаар санал уламжлав. |

8217144139

| № | АГАДҮТ | АГАДҮТ-ын дэд анги | Алдаа зөрчлийн товч утга | Асуудлын ангилал | Мөнгөн дүн (сая.төг) | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гарсан шийдэл | Байгууллагын санал тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гарсан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 8 | Ажил гүйлгээний анги | Зардал | Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны 3 байгууллага, Засаг дарга ерөнхий данснаас 415,550.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүй зарцуулсан нь баримтаар нотлогдохгүй байна. | Санхүүгийн аудитын асуудал | | Материаллаг | 0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-99 | Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; | Хуулийн хэрэгжилт | Уг асуудлыг МУ-ын Ерөнхий аудиторт шалгуулахаар санал уламжлав. | Тайлбаргүй | Тайлбаргүй | Уг асуудлыг МУ-ын Ерөнхий аудиторт шалгуулахаар санал уламжлав. |
| 9 | Ажил гүйлгээний анги | Зардал | Засаг даргын ерөнхий данс нэртэй 100050051000 тоот данснаас 3,438,451.6 мянган төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт, сумдын ой тэмдэглэхэд 1,400,000.0 мянган төгрөгийг, 1,942,611.4 мянган төгрөгийг бусад хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, урсгал зардал, засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсээр байна. | Нийцлийн аудитын асуудал | 3,438.4 | Материаллаг | 3,438.4 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.42-т ""төсвийн ерөнхий данс" гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг", 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай" | Хуулийн хэрэгжилт | Засаг дарга-Албан шаардлага | Тайлбаргүй | Тайлбаргүй | Засаг дарга-Албан шаардлага |
| 10 | Ажил гүйлгээний анги | Орлого, зардал | Төсвийн тодотголоор аймгийн Засаг даргаас ААНОАТ-ыг 7,979,100.0 мянган төгрөгөөр, Есөнбулаг сумаас авах татаас санхүүжилтийг 631,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д өргөн барьсан боловч бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна. | Нийцлийн аудитын асуудал | 0.00 | Материаллаг | 0 | УСНББОУС-1, 2, 3, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98 | Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахад Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим болон дараахь зарчмуудыг удирдлага болгоно:,, 7 дугаар зүйлийн 7.2-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ". | Хуулийн хэрэгжилт | Засаг дарга-Албан шаардлага | Тайлбаргүй | Тайлбаргүй | Засаг дарга-Албан шаардлага |
| | | | Нийт зөрчлийн дүн | | 25,701.0 | 0.0 | 25,701.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

**Бэлтгэсэн**

| | | |
|---|---|---|
| Ахлах аудитор: | | |
| Анхан шатанд хянасан: | Д.Цэрэнханд | 2025.04.18 |
| Аудитын менежер: | Д.Эрдэнэчимэг | 2025.04.18 |
| Хоёр дахь шатанд хянасан: | | |
| Дарга, Тэргүүлэх аудитор | Г.Гүнжидмаа | 2025.04.18 |

**Танилцаж зөвшөөрсөн**

| | | |
|---|---|---|
| Засаг дарга | Г.Чинбат | 2025.04.18 |
| Төсвийн ерөнхий нягтлан бодогч | Д.Ундрахбаяр | 2025.04.18 |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

А0760260

2025 оны 04 сарын 18 өдөр　　　　Дугаар 01/207　　　　Алтай хот

ГАА - 2025 1001 - НА - СТА - ТЕЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Харьяа байгууллагуудын аудитаар 167,579,600.00 (Нэг зуун жаран долоон сая таван зуун далан есөн мянга зургаан зуу) төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,354,315,700.00 (Нэг тэрбум гурван зуун тавин дөрвөн сая гурван зуун арван таван мянга долоон зуу) төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 албан тушаалтанд 153,931,400.00 (Нэг зуун тавин гурван сая есөн зуун гучин нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 16,911,600.00 (Арван зургаан сая есөн зуун арван нэгэн мянга зургаан зуу) төгрөгийн 3 заалт зөвлөмжийг хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Чинбат), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Д.Даваадорж)-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

АУДИТЫН МЕНЕЖЕР　　Д.ЭРДЭНЭЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР　　Д.ЦЭРЭНХАНД

8217144139
ДЮА... 18301

[1] Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Хөгжил хороолол 1402 Утас 70484030

8225041823